

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**  
*2000 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр*  
*Улаанбаатар хот*

**СОГТУУРАХ, МАНСУУРАХ ДОНТОЙ ӨВЧТЭЙ  
ЭТГЭЭДИЙГ ЗАХИРГААНЫ ЖУРМААР АЛБАДАН  
ЭМЧЛЭХ, АЛБАДАН ХӨДӨЛМӨР ХИЙЛГЭХ ТУХАЙ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**  
**Нийтлэг үндэслэл**

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь төрөөс согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг уг өвчнөөс нь ангижруулах зорилгоор албадан эмчлэх, хөдөлмөрийн чадварыг нь харгалзан албадан хөдөлмөр хийлгэхээр эрүүл мэндийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хяналтад авахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. */Энэ зүйлийг 2003 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

**2 дугаар зүйл. Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль тогтоомж**

2.1. Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль тогтоомж нь Захиргааны хариуцлагын тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**3 дугаар зүйл. Албадан эмчилгээ, албадан хөдөлмөрт хамаарагдах этгээд**

3.1. Албадан эмчилгээнд дараахь өвчтэй этгээдийг хамруулна:

3.1.1. согтуурах донтой;

3.1.2. мансуурах донтой.

3.2. Энэ хуулийн 3.1-д заасан өвчний оношилгооны хэмжүүрийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно. */Энэ хэсэгт 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*

3.3. Энэ хуулийн 3.1-д заасан өвчтэй этгээдийг дор дурдсан нөхцөлд албадан хөдөлмөрт хамруулна:

3.3.1. хөдөлмөрийн чадвартай байх;

3.3.2. хийлгэх ажил нь тухайн этгээдийн эрүүл мэндийн байдалд тохирсон байх.

3.4. Насанд хүрээгүй, эсхүл 60-аас дээш настай эрэгтэй, 55-аас дээш настай эмэгтэй, 16 насанд хүрээгүй хүмүүс түүнчлэн жирэмсэн эмэгтэйчүүдийг албадан хөдөлмөрлүүлэхийг хориглоно.

3.5. Албадан хөдөлмөрлөх этгээд нь албадан хөдөлмөрлүүлж байгаа газраас даалгасан ажлыг гүйцэтгэх, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журмыг сахих үүрэгтэй.

**4 дүгээр зүйл. Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх үндэслэл**

4.1. Өвчтэй нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон бөгөөд нийгмийн хэв журмыг зөрчсөн, сайн дураар эмчлүүлэхээс зайлсхийсэн буюу эмчлүүлсний дараа согтууруулах ундаа, мансууруулах бодис дахин хэрэглэсэн этгээдийг шүүхийн шийдвэрийн дагуу албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт явуулж албадан эмчилнэ.

Улсын дээд шүүхийн тайлбар (2007 оны 3 дугаар сарын 12-ны өдөр, тогтоолын дугаар 15):

Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д зааснаар согтуурах, мансуурах донтой этгээдийг шүүхийн шийдвэрийн дагуу албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт албадан эмчлүүлэхэд:

а/ тухайн этгээд согтуурах, мансуурах дон өвчтэй болох нь мэргэжлийн эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон байх;

б/ тухайн этгээд нийгмийн хэв журмыг зөрчсөн байх;

в/тухайн этгээд сайн дураар эмчлүүлэхээс зайлсхийсэн эсхүл эмчлүүлсний дараа согтууруулах, мансууруулах бодис дахин хэрэглэсэн байх;

үндэслэл нэг дор бүрдсэн нөхцөлд тухайн этгээдийг энэ хуульд заасан журмын дагуу албадан эмчилгээнд хамруулна.

“Эмнэлгийн дүгнэлт” гэдэгт ерөнхий мэргэжлийн болон сэтгэцийн эмгэг, наркологийн гурваас доошгүй эмч нарын бүрэлдэхүүнтэй комиссын дүгнэлтийг ойлгоно.

“Нийгмийн хэв журмыг зөрчсөн” гэдэгт нийгмийн хэв журмыг зөрчиж, захиргааны арга хэмжээ авагдсан, эсхүл авагдаагүй боловч эрх зүйн болон нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдэхүйг хамааруулна.

“Эмчлүүлсний дараа” гэдэгт согтуурах, мансуурах дон өвчнөөс ангижруулах зорилготой сайн дурын эсхүл албадан эмчилгээнд урьд өмнө хамрагдаж байсныг хэлнэ.

4.2. Энэ хуулийн 4.1-д заасан газарт байх хугацаанд албадан эмчилгээ хийлгэх этгээдээр эмчилгээ, үйлчилгээний зардлыг өөрөөр нь нөхөн төлүүлэх зорилгоор шүүхийн шийдвэрээр албадан хөдөлмөр хийлгэж болно.

## **5 дугаар зүйл. Эмнэлгийн дүгнэлт гаргуулах**

5.1. Сум, баг, хорооны Засаг дарга, байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага, цагдаагийн байгууллага, иргэн нийгмийн хэв журам зөрчсөн этгээдийг энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан өвчтэй эсэх талаар дүгнэлт гаргуулахаар эмнэлгийн байгууллагад хүсэлт гаргаж болно.

Улсын дээд шүүхийн тайлбар (2007 оны 3 дугаар сарын 12-ны өдөр, тогтоолын дугаар 15):

Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан “нийгмийн хэв журам зөрчсөн” үйлдэлд нь захиргааны хариуцлага ногдуулах эсэх асуудлыг тухайн этгээдийг албадан эмчилгээнд хамруулах асуудлаас тусдаа Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу шийдвэрлэнэ.

5.2. Эмнэлэг тухайн этгээдийг өвчтэй эсэхийг тогтоосон дүгнэлтээ материал хүлээж авснаас хойш 48 цагийн дотор гаргаж хүсэлт тавьсан байгууллага, иргэнд өгнө.

## **6 дугаар зүйл. Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай шүүхийн шийдвэр гаргах, түүнийг биелүүлэх**

6.1. Сум, баг, хорооны Засаг дарга, цагдаагийн байгууллага нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан өвчтэй этгээдэд холбогдох дор дурдсан материалыг бүрдүүлж шүүхэд өгнө.

6.1.1. тухайн этгээдийг албадан эмчилгээнд явуулах тухай зохих байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлт;

6.1.2. сум, баг, хорооны Засаг дарга, цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

6.1.3. тухайн этгээд согтуурах, мансуурах донтой өвчтэй болсон тухай эмнэлгийн дүгнэлт.

6.2. Шүүх шаардлагатай гэж үзвэл дээр дурдсанаас бусад материалыг шаардан авч болно.

Улсын дээд шүүхийн тайлбар (2007 оны 3 дугаар сарын 12-ны өдөр, тогтоолын дугаар 15):

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан “шүүх шаардлагатай гэж үзвэл дээр дурдсанаас бусад материалыг шаардан авч болно” гэдгийг энэ зүйлийн 6.1-д заасан хүсэлт, тодорхойлолт,

*дүгнэлтээс гадна тухайн этгээд урьд өмнө эмчилгээнд хамрагдсан эсэх болон захиргааны арга хэмжээ авагдаж байсан бол энэ тухай баримт, холбогдох гэрчийн мэдүүлэг зэрэг уг этгээдийг албадан эмчилгээнд явуулах зайлшгүй шаардлагатай болохыг нотлох аливаа баримтыг шүүх шаардах эрхтэй гэж ойлгоно.*

6.3. Шүүх хуралдааныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу явуулж, шүүхийн шийдвэр гаргана.

*Улсын дээд шүүхийн тайлбар (2007 оны 3 дугаар сарын 12-ны өдөр, тогтоолын дугаар 15):*

*Мөн зүйлийн 6.3-т заасан “шүүх хуралдааныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу явуулж, шүүхийн шийдвэр гаргана” гэсний дагуу шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн арван гуравдугаар бүлэгт заасан хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааны журмаар хүсэлтийг шийдвэрлэж, мөн хуулийн 135 дугаар зүйлийн 135.2.14 дэх хэсгийг шийдвэр гаргахдаа удирдлага болгоно.*

*Шүүх тухайн этгээдийн тайлбарыг сонсож, шийдвэрт тусгах боловч түүнийг хариуцагч гэж үзэхгүйгээс гадна согтуурах, мансуурах дон өвчтэйн улмаас албадан эмчилгээнд хамрагдах шаардлагатай болсон үйл баримтыг тогтоож байгаа тул тухайн хэрэгт эрх зүйн маргаан байхгүй учир мэтгэлцээн явагдахгүй.*

6.4. Шүүхийн шийдвэрийг гарсан өдрөөс нь хойш тухайн өвчтэй этгээд, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хугацааны дотор давж заалдах эрхтэй.

*Улсын дээд шүүхийн тайлбар (2007 оны 3 дугаар сарын 12-ны өдөр, тогтоолын дугаар 15):*

*Мөн зүйлийн 6.4-т заасан “шүүхийн шийдвэрийг гарсан өдрөөс нь хойш тухайн өвчтэй этгээд, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хугацааны дотор давж заалдах эрхтэй” гэдгийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 134 дүгээр зүйлийн 134.1-д “онцгой ажиллагааны журмаар шүүх хянан шийдвэрлэх хэргийг бусад хууль болон энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол энэ хуулиар тогтоосон ерөнхий журмын дагуу шийдвэрлэнэ” гэж заасантай нийцүүлж, эмчилгээнд хамрагдах этгээд, түүний төлөөлөгч, өмгөөлөгч нь энэ зүйлд заасны дагуу шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 14 хоногийн дотор давж заалдах гомдол гаргана гэж ойлгоно.*

*Харин хүсэлт гаргасан этгээд хэргийн оролцогчийн хувьд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлийн 120.2.-т заасны дагуу шийдвэрийг гардан авсан өдрөөс хойш давж заалдах журмаар бол 14 хоногийн дотор, хяналтын журмаар бол 30 хоногийн дотор тус тус гомдол гаргаж болно.*

6.5. Шүүхийн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн биелүүлнэ.

6.6. Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай шүүхийн шийдвэр гарах хүртэл тухайн этгээдийг саатуулах, шүүхийн шийдвэр гарсны дараа албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт хүргэх ажиллагааг цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ.

6.7. Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар тухайн этгээдийг хүлээж авахдаа дор дурдсан бичиг баримтыг шалгана:

6.7.1. шүүхийн шийдвэрийн хуулбар;

6.7.2. эмнэлгийн байгууллагын дүгнэлт;

6.7.3. иргэний үнэмлэх;

6.7.4. эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын дэвтэр;

6.7.5. тухайн этгээдэд холбогдох хэргийн материалын хуулбар.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ  
АЛБАДАН ЭМЧЛЭХ, АЛБАДАН ХӨДӨЛМӨР**

## ХИЙЛГЭХ ГАЗАР, ТҮҮНИЙ САНХҮҮЖИЛТ

### 7 дугаар зүйл. Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар

7.1. Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрыг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

### 8 дугаар зүйл. Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын харьяалал

8.1. Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяалалд байх бөгөөд түүний албадан эмчлэх мэргэжлийн удирдлагыг эрүүл мэндийн байгууллага, албадан хөдөлмөрлүүлэх мэргэжлийн удирдлага болон харуул хамгаалалтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тус тус хэрэгжүүлнэ. /Дээрх 8 дугаар зүйлийг 2003 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

### 9 дүгээр зүйл. Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын санхүүжилт

9.1. Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. /Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

9.2. Энэ хэсгийг 2003 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.

### 10 дугаар зүйл. Албадан эмчилгээ, үйлчилгээний зардлыг нөхөн төлүүлэх

10.1. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан өвчтэйн улмаас албадан эмчлүүлж байгаа этгээдээр эмчилгээ, үйлчилгээнд нь гарсан зардлыг албадан хөдөлмөр хийлгэж өөрөөр нь нөхөн төлүүлж болно.

[Улсын дээд шүүхийн тайлбар \(2007 оны 3 дугаар сарын 12-ны өдөр, тогтоолын дугаар 15\):](#)

*Хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан өвчтэйн улмаас албадан эмчлүүлж байгаа этгээдээр эмчилгээ, үйлчилгээнд нь гарсан зардлыг албадан хөдөлмөр хийлгэж, өөрөөр нь нөхөн төлүүлж болно” гэж заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан эмчилгээнд хамрагдаж буй этгээд албадан эмчлэх журам, эмчилгээний горим зөрчсөнөөс эмчилгээний нэмэгдэл зардал гарсан, эмнэлгийн дүрэм зөрчиж албадан эмчлэх байгууллагад хохирол учруулсан зэрэг тохиолдолд энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан зарчим, үндэслэлийн дагуу албадан хөдөлмөр хийлгэх, эмчилгээ, үйлчилгээнд гарсан зардлыг өөрөөр нь нөхөн төлүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ.*

*Албадан хөдөлмөрлүүлэх тухай хүсэлтийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар тухайн орон нутгийн анхан шатны шүүхэд гаргана.*

10.2. Албадан эмчилгээний хугацаанд гарсан зардлыг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын тодорхойлолтыг үндэслэн шүүхийн шийдвэр биелүүлэх журмаар гаргуулна.

[Улсын дээд шүүхийн тайлбар \(2007 оны 3 дугаар сарын 12-ны өдөр, тогтоолын дугаар 15\):](#)

*Мөн зүйлийн 10.2.-т заасан “албадан эмчилгээний хугацаанд гарсан зардлыг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын тодорхойлолтыг үндэслэн шүүхийн шийдвэр биелүүлэх журмаар гаргуулна” гэдгийг шүүх хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан хугацаа болон албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газраас тодорхойлсон баримтыг үндэслэн албадан эмчилгээний зардлын хэмжээг шийдвэрт тус тус зааж, уг шийдвэрийг шүүхийн шийдвэр биелүүлэх журмаар гүйцэтгэнэ гэж ойлгоно.*

## ГУРАВДУГААР БҮЛЭГ АЛБАДАН ЭМЧЛЭХ

### 11 дүгээр зүйл. Албадан эмчилгээ хийх

11.1. Албадан эмчилгээг тухайн өвчний үед баримталдаг эмчилгээний нийтлэг зарчим, аргачлал, стандартын дагуу явуулах ба дараахь зарчмыг баримтална.

11.1.1.хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;

11.1.2.хүний эрүүл мэндэд харшлахгүй эм, бэлдмэлийг ашиглах;

11.1.3.эмчлүүлэгчийн нууцыг хадгалах.

11.2. Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар эмчлүүлж байгаа этгээдэд зайлшгүй шаардлагатай шинжилгээ, эмчилгээг цаг тухайд нь хийж албадан эмчилгээний явцыг өвчний түүхэнд үнэн зөв, тодорхой бичнэ.

11.3. Согтуурах, мансуурах донтой этгээд эмчлүүлэхээс зайлсхийх боломжгүй, байнгын харуул хамгаалалт бүхий эмнэлэгт албадан эмчилгээг явуулна. */Энэ хэсгийг 2003 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

11.4. Албадан эмчлэх газрын нөхцөл, дэглэмийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага, албадан эмчлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус Улсын ерөнхий прокурортой хамтран батална. */Энэ хэсгийг 2003 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

11.5. Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь эмчлүүлэгч этгээдийн биеийн байдал, эмчилгээний үр дүнг харгалзан эмчилгээг хугацаанаас нь өмнө зогсоох тухай хүсэлтээ шүүхэд гаргаж болно.

[Улсын дээд шүүхийн тайлбар \(2007 оны 3 дугаар сарын 12-ны өдөр, тогтоолын дугаар 15\):](#)

*Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5-д “албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь эмчлүүлэгч этгээдийн биеийн байдал, эмчилгээний үр дүнг харгалзан эмчилгээг хугацаанаас нь өмнө зогсоох тухай хүсэлтээ шүүхэд гаргаж болно” гэж заасны дагуу албадан эмчилгээ, албадан хөдөлмөр хийлгэх газар нутаг дэвсгэрийн харьяаллын анхан шатны шүүхэд хүсэлт гаргана.*

*Энэ зүйл, хэсэгт “эмчлүүлэгч этгээдийн биеийн байдал, эмчилгээний үр дүнг харгалзан”, мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.-т “тухайн этгээдийн эмчилгээний үр дүнг харгалзан мэргэжлийн эмч нарын комиссын дүгнэлтийг үндэслэн” гэж тус тус заасныг мэргэжлийн эмч нарын дүгнэлтээр эмчилгээ бүрэн хийгдсэн, эсхүл хугацаанаас нь өмнө эмчилгээг зогсоох шаардлагатай аль ч тохиолдолд албадан эмчилгээний хугацааг шүүхийн шийдвэрээр дуусгавар болгоно гэж ойлгоно.*

11.6. Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар эмчилгээ дууссан тухай мэдэгдлийг эмчлүүлэгчийн харьяалах нутаг дэвсгэрийн Засаг дарга, цагдаагийн байгууллагад 7 хоногийн дотор хүргүүлнэ.

## **12 дугаар зүйл. Албадан эмчлэх хугацаа**

12.1.Албадан эмчилгээг өвчний онцлог, эмчилгээний үр дүнгээс шалтгаалан гурваас зургаан сар хүртэл, давтан эмчлүүлэх тохиолдолд зургаан сараас нэг жил хүртэл хугацаатай хийнэ.

[Улсын дээд шүүхийн тайлбар \(2007 оны 3 дугаар сарын 12-ны өдөр, тогтоолын дугаар 15\):](#)

*Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан албадан эмчилгээний хугацааг өвчний онцлог, эмчилгээний үр дүнгээс шалтгаалан эмнэлгийн байгууллага тогтооно. Шүүх шийдвэртээ албадан эмчилгээний хугацааг тогтоохгүй.*

12.2. Албадан эмчилгээний хугацаа нь тухайн этгээдийн эмчилгээний үр дүнг харгалзан мэргэжлийн эмч нарын комиссын дүгнэлтийг үндэслэн шүүхийн шийдвэрээр дуусгавар болно. */Дээрх 12 дугаар зүйлийг 2003 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/*

Улсын дээд шүүхийн тайлбар (2007 оны 3 дугаар сарын 12-ны өдөр, тогтоолын дугаар 15):

*Мөн зүйлийн 12.2.-т заасан “мэргэжлийн эмч нарын комиссын дүгнэлт” гэдэгт ерөнхий мэргэжлийн болон сэтгэцийн эмгэг, наркологийн гурваас доошгүй эмч нарын бүрэлдэхүүнтэй комиссын дүгнэлтийг ойлгоно. Уг дүгнэлтээр тухайн өвчтөнд архины шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийн эмчилгээ, оношлогооны стандартын дагуу эмчилгээ бүрэн хийгдсэн, эсхүл албадан эмчилгээ хийж болохгүй сэтгэцийн болон бусад хүнд өвчтэй болохыг тогтоосон байвал зохино.*

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АЛБАДАН ХӨДӨЛМӨРЛҮҮЛЭХ**

### **13 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх**

13.1. Эмчлүүлэгч этгээдийг албадан хөдөлмөрлүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

13.1.1.хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;

13.1.2.хуульд заасан үндэслэл, журмыг баримтлан ажил хийлгэх;

13.1.3.тухайн этгээдийн мэргэжил, хөдөлмөрийн чадварыг харгалзан үзэх;

13.1.4.хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлөөр хангах;

13.1.5.гүйцэтгэсэн ажлын хэмжээ, чанарт тохирсон цалин хөлс олгох ба энэ хөлсний хэмжээ нь Засгийн газраас баталсан цалин хөлсний доод хэмжээнээс доошгүй байх.

13.2. Эмчлүүлэгч этгээдийг дараахь тохиолдолд ажиллуулахыг хориглоно:

13.2.1.хүнд, хортой нөхцөл;

13.2.2.тусгай мэргэжил шаардагдах ажил;

13.2.3.эмчилгээнд шууд харшлах нөхцөл.

13.3. Эмчлүүлэгч этгээдийг эрүүл мэндийн улмаас албадан хөдөлмөр хийлгэж болохгүй тохиолдолд албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь албадан хөдөлмөрөөс чөлөөлүүлэх хүсэлтээ шүүхэд гаргана.

13.4. Албадан хөдөлмөр хийлгэх ажил, амралтын цагийн горимыг Хөдөлмөрийн тухай хууль-ийг үндэслэн тогтооно.

13.5. Албадан хөдөлмөрийн норм, үнэлгээг тухайн ажилд хамаарах нийтлэг норм, үнэлгээг баримтлан тогтооно.

13.6. Албадан хөдөлмөрлөж байгаа этгээдийн цалин хөлсийг картаар тооцно. Картад энэ хуулийн 9.2-т заасан зардлыг тусгаж түүнийг цалин хөлснөөс нь суутгана. Үлдсэн хэсгийг албадан эмчилгээ дууссаны дараа эмчлүүлэгч этгээдэд олгоно.

13.7. Хуульд өөрөөр заагаагүй бол албадан хөдөлмөрлөхтэй холбогдсон бусад харилцааг хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

13.8. Албадан хөдөлмөрлөж байгаа этгээд гэр бүлийн болон бусад хүнтэй чөлөөтэй уулзах, эргэлт, илгээмж авах, явуулах эрхтэй.

### **14 дүгээр зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх хугацаа**

14.1. Албадан хөдөлмөрлүүлэх хугацаа нь тухайн этгээдийг албадан эмчлэх хугацаанаас илүүгүй байна.

14.2. Энэ хуулийн 12.2-т заасан албадан эмчилгээний хугацаа дуусгавар болсон тохиолдолд албадан хөдөлмөрлүүлэх хугацаа дуусгавар болно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

**15 дугаар зүйл. Эмчлүүлэгч этгээдийг иргэний бүртгэл, даатгалд хамруулах, нийгмийн халамжийн байгууллагад шилжүүлэх**

15.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага иргэний үнэмлэхгүй этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх хугацаанд багтаан зохих журмын дагуу иргэний бүртгэлд хамруулах арга хэмжээ авна. */Энэ хэсэгт 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*

15.2. Сум, баг, хороо, дүүргийн Засаг дарга эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд хамрагдаагүй этгээдийг албадан эмчлүүлэх хугацаанд багтаан даатгалд хамруулах арга хэмжээ авна.

15.3. Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь эмчлүүлэгч этгээд хууль ёсны асран хамгаалах, харгалзан дэмжих хүнгүй, гэр оронгүй бол эмчилгээ дууссаны дараа түүнийг нийгмийн халамжийн байгууллагад шилжүүлэх тухай саналыг орон нутгийн Засаг даргад тавьж болно.

**16 дугаар зүйл. Гомдол гаргах**

16.1. Эмчлүүлэгч этгээд, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэхтэй холбогдсон гомдлыг шүүхэд гаргаж болно.

*Улсын дээд шүүхийн тайлбар (2007 оны 3 дугаар сарын 12-ны өдөр, тогтоолын дугаар 15):*

*Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.-д заасан гомдлыг эмчлүүлэгч этгээд, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь нутаг дэвсгэрийн харьяаллын анхан шатны шүүхэд гаргана.*

*Шүүх тухайн гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн арван дөрөвдүгээр бүлэгт заасан журмын дагуу хянан шийдвэрлэнэ.*

**17 дугаар зүйл. Хариуцлага**

17.1. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан өвчтэй этгээд албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт байхдаа эмчлүүлэх, хөдөлмөрөөс зайлсхийсэн буюу эмнэлгээс оргосон тохиолдолд цагдаагийн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага эрэн сурвалжилж, түүнтэй холбогдож гарсан зардлыг өөрөөр нь нөхөн төлүүлэхийн хамт эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу ЗО хоног хүртэл хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна. */Энэ хэсэгт 2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/*

*Улсын дээд шүүхийн тайлбар (2007 оны 3 дугаар сарын 12-ны өдөр, тогтоолын дугаар 15):*

*Хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.-д заасан баривчлах шийтгэлийг шүүх Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийтгэвэрээр ногдуулна.*

*Баривчлах шийтгэлийн хугацааг албадан эмчилгээний хугацаанд оруулж тооцохгүй.*

**18 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

18.1. Энэ хуулийг 2000 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.